



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БНА-2026/007/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2026 оны 03 дугаар сарын 15

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Ахлах аудитор: М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитор: Н.Бүнчинсүрэн
Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsuren@audit.gov.mn

НЭГ.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2026.03.16 № 2/148

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд ажиллагсдад сар бүр үр дүнгийн урамшууллыг 40 хүртэлх хувиар тооцон нийт 601,165.8 мянган төгрөгийн урамшуулал олгосон байхад Баянхонгор Эрчим хүч ЦТХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 05 дугаар тушаалаар 2024 оны жилийн үр дүнгийн урамшуулалд 386,695.6 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.

6426050419
/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-
албан тоот.docx

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нийт зардал 26,808,587.5 мянган төгрөг баталж, 27,567,507.4 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан ба үйл ажиллагааны зардлыг 758,919.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн ажилласан байна. Энэ нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2025.10.29-ны 656 дугаар тогтоолоор Диспетчерийн үндэсний төвөөс худалдан авах цахилгааны тарифыг 2025.10.01-ний өдрөөс 2025.12.31-ний өдрийг дуустал хугацаанд 240.15-аас 271.33 төг/кВт.ц болгон нэмэгдүүлсэн нь төлөвлөсөн хэмжээнээс 1,483,666.9 мянган төгрөгийн зардал хэтэрсэнтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 95.15 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

3

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ



ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,870,013,341.01	4,546,590,561.54
31	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,171,867,318.35	394,786,511.69
31200	1.1.1.02 Банкинд байгаа бэлэн мөнгө	1,171,867,318.35	394,786,511.69
31210	1.1.1.02.01 Төгрөг	1,171,867,318.35	394,786,511.69
31213	1.1.1.02.01.03 Арилжааны банк дахь харилцах	1,171,867,318.35	394,786,511.69
33	1.1.3 АВЛАГА	2,041,490,328.32	2,728,073,411.38
33500	1.1.3.07 Бусад авлага	2,041,490,328.32	2,728,073,411.38
33510	1.1.3.07.01 Байгууллагаас авах авлага	2,041,490,328.32	2,728,073,411.38
34	1.1.4 УРЬДЧИЛГАА	592,616,708.85	508,742,512.38
34710	1.1.4.07 Урьдчилгаа тооцоо	592,616,708.85	508,742,512.38
34711	1.1.4.07.01 Бараа материал бэлтгэх урьдчилгаа	592,616,708.85	508,742,512.38
35	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	1,064,038,985.49	914,988,126.09
35400	1.1.5.04 Хангамжийн материал	1,064,038,985.49	914,988,126.09
35420	1.1.5.04.02 Аж ахуйн материал	1,064,038,985.49	914,988,126.09
2	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	20,945,192,241.92	20,697,990,903.94
39	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20,945,192,241.92	20,697,990,903.94
39200	1.2.2.02 Биет хөрөнгө	20,496,479,202.31	20,190,912,170.11
39201	1.2.2.02.01 Барилга, байгууламж, орон сууц	24,659,000,211.74	24,815,852,943.67
39202	1.2.2.02.02 Хуримтлагдсан элэгдэл	(8,640,375,928.53)	(9,036,651,622.74)
39203	1.2.2.02.03 Авто-тээврийн хэрэгсэл	783,231,326.98	1,066,774,397.05
39204	1.2.2.02.04 Хуримтлагдсан элэгдэл	(482,526,036.02)	(450,473,094.34)
39205	1.2.2.02.05 Машин тоног төхөөрөмж(компьютер)	6,010,330,435.72	6,386,829,627.57
39206	1.2.2.02.06 Хуримтлагдсан элэгдэл	(2,487,937,323.98)	(2,763,197,868.38)
39207	1.2.2.02.07 Тавилга, аж ахуйн эд хогшил	472,649,852.82	590,239,200.09
39208	1.2.2.02.08 Хуримтлагдсан элэгдэл	(381,381,306.38)	(418,461,412.81)
39214	1.2.2.02.14 Бусад үндсэн хөрөнгө	1,103,033,106.85	-
39215	1.2.2.02.15 Хуримтлагдсан элэгдэл	(539,545,136.89)	-
39300	1.2.2.03 Биет бус хөрөнгө	448,713,039.61	507,078,733.83
39303	1.2.2.03.03 Бусад биет бус хөрөнгө	465,672,196.79	572,210,560.42
39304	1.2.2.03.04 Хуримтлагдсан элэгдэл	(16,959,157.18)	(65,131,826.59)
3	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	25,815,205,582.93	25,244,581,465.48
4	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	827,369,248.82	659,568,702.54
41	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	399,486,819.79	275,867,616.87
41300	2.1.1.03 Өглөг	399,486,819.79	275,867,616.87
41320	2.1.1.03.02 Бараа үйлчилгээний зардлын өглөг	57,922,401.22	275,867,616.87
41360	2.1.1.03.06 Бусад өглөг	341,564,418.57	-
41363	2.1.1.03.06.03 Татварын өглөг /ТӨҮГ/	341,564,418.57	-
42	2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	427,882,429.03	383,701,085.67
42200	2.1.2.02 Урт хугацаат зээл	427,882,429.03	383,701,085.67
42220	2.1.2.02.02 Гадаад валют	427,882,429.03	383,701,085.67
42230	2.1.2.02.02.10 Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	427,882,429.03	383,701,085.67
5	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	24,987,836,334.11	24,585,012,762.94
51	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	24,987,836,334.11	24,585,012,762.94
51100	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	20,804,390,157.07	20,432,898,794.94
511002	2.2.1.01.02 Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	20,804,390,157.07	20,432,898,794.94
51200	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	(843,895,404.98)	(875,227,614.02)
51210	2.2.1.08.01 Өмнөх үеийн үр дүн	(1,841,341,967.95)	(843,895,404.98)
51220	2.2.1.08.02 Тайлант үеийн үр дүн	997,446,562.97	(31,332,209.04)
51300	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,027,341,582.02	5,027,341,582.02
6	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	25,815,205,582.93	25,244,581,465.48

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	18,635,506,602.69	27,536,175,173.91
12	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,635,506,602.69	27,536,175,173.91
120	1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	18,635,506,602.69	27,536,175,173.91
120004	1.1.1.04.1.04 Төсөв байгууллагын өөрийн орлого	17,884,209,907.13	27,448,637,844.59
1200041	1.1.1.04.1.04.01 Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,884,209,907.13	27,448,637,844.59
120017	1.1.1.04.1.13 Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	47,498,800.80	87,537,329.32
120018	1.1.1.04.1.14 Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	703,797,894.76	-
II	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	17,638,060,039.72	27,567,507,382.95
21	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	17,638,060,039.72	27,567,507,382.95
210	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,638,060,039.72	27,567,507,382.95
2109	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	17,638,060,039.72	27,567,507,382.95
210901	1.1.2.01.1.09.01 Бараа үйлчилгээний бусад зардал	16,517,439,047.19	26,456,104,831.41
210903	1.1.2.01.1.09.03 Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,120,620,992.53	1,111,402,551.54
III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	997,446,562.97	(31,332,209.04)
VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	997,446,562.97	(31,332,209.04)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	15,131,526,672.33	25,438,156,304.68
12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,131,526,672.33	25,438,156,304.68
120	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	15,131,526,672.33	25,438,156,304.68
120004	1.1.1.1.04.1.04 Төсөв байгууллагын өөрийн орлого	15,131,526,672.33	25,438,156,304.68
1200041	1.1.1.1.04.1.04.01 Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,131,526,672.33	25,438,156,304.68
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,207,998,579.27	24,752,128,578.29
21	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	14,207,998,579.27	24,752,128,578.29
210	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,207,998,579.27	24,752,128,578.29
2109	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	14,207,998,579.27	24,752,128,578.29
210901	1.1.1.2.01.1.09.01 Бараа үйлчилгээний бусад зардал	14,207,998,579.27	24,752,128,578.29
III	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	923,528,093.06	686,027,726.39
V	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	243,177,619.11	1,463,108,533.05
22	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	243,177,619.11	1,463,108,533.05
2200	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	243,177,619.11	1,463,108,533.05
225106	1.1.2.2.01.1.06 Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	243,177,619.11	1,463,108,533.05
VI	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(243,177,619.11)	(1,463,108,533.05)
VIII	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	680,350,473.95	(777,080,806.66)
101	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	491,516,844.40	1,171,867,318.35
20	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,171,867,318.35	394,786,511.69

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	18,673,854,878.25	5,027,341,582.02	(414,604,583.89)	23,286,591,876.38
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн	1,426,737,384.06	-	(1,426,737,384.06)	-

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, эдийн засгийн зорилтот түвшинд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	бодлогын өөрчлөлт				
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,100,592,262.31	5,027,341,582.02	(1,841,341,967.95)	23,286,591,876.38
5	1.1.1.1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	703,797,894.76	-	-	703,797,894.76
9	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	-	-	997,446,562.97	997,446,562.97
10	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,804,390,157.07	5,027,341,582.02	(843,895,404.98)	24,987,836,334.11
11	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	20,804,390,157.07	5,027,341,582.02	(843,895,404.98)	24,987,836,334.11
13	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,804,390,157.07	5,027,341,582.02	(843,895,404.98)	24,987,836,334.11
17	1.5 Өмчид гарсан өөрчлөлт	(371,491,362.13)	-	-	(371,491,362.13)
19	1.7 Тайлант үеийн үр дүн	-	-	(31,332,209.04)	(31,332,209.04)
20	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	20,432,898,794.94	5,027,341,582.02	(875,227,614.02)	24,585,012,762.94

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

№	Зардлын төрөл	Мөрийн дугаар	Тайлант оны		Зөрүү	хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
0	ХАЦЭХ		19,352,223,576.9	20,835,890,480.7	(1,483,666,903.8)	107.7%
1	Шатахууны зардал	1	45,508,096.2	45,367,257.5	140,838.7	99.7%
2	Тээврийн зардал	2			-	
3	Сэлбэг хэрэгсэл	3	21,515,790.2	20,972,380.6	543,409.6	97.5%
4	Урсгал засвар	4	122,724,100.0	113,212,679.1	9,511,421.0	92.2%
5	Материал, хангамжийн материал	5	1,000,000.0	583,643.4	416,356.6	58.4%
6	Үндсэн ба нэмэгдэл цалин, урамшуулал	6	3,893,824,561.7	3,614,617,434.5	279,207,127.2	92.8%
7	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	7	564,604,561.4	505,180,251.3	59,424,310.2	89.5%
8	Ашиглалтын зардал-Цахилгаан	8	28,104,750.0	28,103,948.9	801.1	100.0%
9	Ашиглалтын зардал-Дулаан	9	142,252,600.0	142,247,936.4	4,663.6	100.0%
10	Ашиглалтын зардал-Ус	10	7,477,300.0	5,463,040.0	2,014,260.0	73.1%
11	Албан томилолтын зардал	11	24,896,000.0	19,488,333.0	5,407,667.0	78.3%
12	Конторын хангамжийн зардал	12	4,246,300.0	4,243,971.5	2,328.5	99.9%
13	Харилцаа холбооны зардал	13	22,813,800.0	21,576,651.5	1,237,148.5	94.6%
14	Харуул хамгаалалтын зардал	14	43,091,000.0	38,095,909.1	4,995,090.9	88.4%
15	Хөдөлмөр хамгааллын зардал	15	84,024,000.0	79,558,502.1	4,465,497.9	94.7%
16	Даатгалын зардал	16	20,743,200.0	20,741,415.0	1,785.0	100.0%

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, эдийн засгийн зорилтот түвшинд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

17	Галын аюулаас хамгаалах зардал	17			-	
18	Гүйцэтгэх удирдлагын зардал	18	12,000,000.0	6,720,585.6	5,279,414.4	56.0%
19	Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал	19	60,299,125.0	31,585,718.7	28,713,406.3	52.4%
20	Хяналтын зөвлөлийн зардал	20			-	
21	Борлуулалт, маркетингийн зардал	21	10,553,100.0	10,552,620.8	479.2	100.0%
22	Диспетчерийн зардал	22			-	
23	Зохицуулалтын үйлчилгээний хөлс	23	20,825,200.0	20,800,000.0	25,200.0	99.9%
24	Гадны үйлчилгээний хөлс	24	27,391,800.0	27,257,609.2	134,190.8	99.5%
25	Түрээсийн зардал	25			-	
26	Сургалтын зардал	26	11,156,000.0	10,151,381.8	1,004,618.2	91.0%
27	Найдваргүй авлагын зардал	27			-	
28	Үйл ажиллагааны бусад зардал	28	1,242,200.0	1,210,690.3	31,509.7	97.5%
29	Гамшигаас хамгаалах зардал				-	
	Үйл ажиллагааны зардлын дүн	29	5,170,254,248.5	4,767,731,960.3	402,522,288.2	92.2%
30	Ерөнхий хэрэглээний үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	30	249,700,000.0	232,893,142.3	16,806,857.7	93.3%
31	Үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	31	1,359,500,000.0	1,019,289,290.6	340,210,709.4	75.0%
	Элэгдлийн зардлын дүн	32	1,609,200,000.0	1,252,182,432.9	357,017,567.1	77.8%
32	Үл хөдлөх хөрөнгийн татвар	33	22,827,100.0	22,826,849.6	250.4	100.0%
33	АТӨЯХ-ийн албан татвар	34	1,366,600.0	1,235,414.0	131,186.0	90.4%
34	Газрын төлбөр	35	631,700.0	167,140.0	464,560.0	26.5%
35	Бусад татвар хураамж	36		9,445,429.8	(9,445,429.8)	
	Орлогын албан татвараас бусад татварын дүн	37	24,825,400.0	33,674,833.4	(8,849,433.4)	135.6%
36	Хүүгийн зардал-Урт хугацаат зээл	39	53,216,600.0	4,176,373.3	49,040,226.7	7.8%
37	Ажиллагсдын нийгмийн зардал	40	181,083,500.0	171,282,999.0	9,800,501.0	94.6%
	Хөрөнгө оруулалтын өгөөжөөр нөхөгдөх зардлын дүн	41	234,300,100.0	175,459,372.3	58,840,727.7	74.9%
38	Үйл ажиллагааны бус зардал	42	417,784,162.0	502,568,303.3	(84,784,141.3)	120.3%
39	Валютын ханшны алдагдал	43			-	
	НИЙТ ЗАРДАЛ /29+32+37+41+42+43/	45	26,808,587,487.4	27,567,507,382.9	(758,919,895.5)	102.8%
40	Борлуулалтын орлого	46	21,063,945,805.4	21,342,711,607.9	(278,765,802.5)	101.3%
41	Түгээх үйлчилгээ орлого		5,326,857,520.0	5,306,851,520.0	20,006,000.0	99.6%
42	Бусад орлого	48	417,784,162.0	886,612,046.0	(468,827,884.0)	212.2%
	НИЙТ ОРЛОГО /46+47-45/	49	26,808,587,487.4	27,536,175,173.9	(727,587,686.5)	102.7%
43	ТАТВАРЫН ДАРААХИ АШИГ/АЛДАГДАЛ	50	(0.0)	(31,332,209.04)		

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 567,669.8 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс, 13,108.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг арилгах 155,865.4 мянган төгрөгийн 3 албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 398,695.6 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийг санхүүгийн болон нийцлийн гэж ангилсан бөгөөд санхүүгийн тайлангийн 168,974.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил

нь бидний тогтоосон 178,985.1 мянган төгрөгийн гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 10,010.9 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1.Төлбөрийн акт

3.1.1. Тус байгууллага нь "Би Эйч Энд Ди ХХК-тай гэрээ байгуулан халаалт дулааныг авдаг бөгөөд Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 51 дүгээр тогтоолын хавсралтаар "Үйлдвэр, аж ахуй нэгж, байгууллага"-д борлуулах дулааны тарифыг 2,140 төгрөгөөр тогтоосон байхад "Төсөвт байгууллага"-д борлуулах дулааны тариф 2,360 төгрөгөөр тооцож 13,108.9 мянган төгрөгийн халаалтын зардал илүү төлсөн байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Баянхонгор аймгийн зохицуулах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 51 тогтоолыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2026 оны халаалтын зардлаас суутган тооцож орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2.Албан шаардлага

3.2.1. Цахим төлбөрийн баримтын системээс төлбөрийн баримтын жагсаалтыг татан авч мөнгөн гүйлгээний журналтай тулгаж үзэхэд 46,778.4 мянган төгрөгийн худалдан авалтыг И баримт үүсгээгүй байхад гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын 6.5. Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” заалтуудыг мөрдөөгүй байна. гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим төлбөрийн баримтын системд нөхөн байршуулах албан шаардлага хүргүүлэв.

3.2.2. Тухай байгууллагын биет бус хөрөнгөд 12 төрлийн 41,707 м2 газар бүртгэлтэй байгаа бөгөөд цахим санд (egazar.gov.mn)-д 29,037 м2, 23 төрлийн газар бүртгэлтэй байгаа бөгөөд 12,670 м2 газар зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана” гэсэн заалттай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын нэр дээр бүртгэлтэй газрын хэмжээг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай тулган баталгаажуулж нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгах

3.2.3. Тайлант онд өөрийн үйлдвэрлэсэн 1,444,107.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлого авсан бөгөөд тус байгууллагын өмч хамгаалах зөвлөл 1,321,875.6 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтад дүгнэлт гаргасан ба зарим ажлуудын гүйцэтгэлийн дүн зөрүүтэй байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолоор батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 2.4-т "Өмч хамгаалах зөвлөл нь ажлын төлөвлөгөөг энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заасан загварын дагуу боловсруулж жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны өдөрт багтаан хуулийн этгээдийн удирдлагаар батлуулж ажиллана." 3 дугаар зүйлийн 3.3-т "Өмч хамгаалах зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж, данснаас хасах зэрэг эд хөрөнгийн зохицуулалт, төрийн өмчийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг судалж, дараах байдлаар зөвлөмж дүгнэлт гаргана." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өөрийн үйлдвэрлэсэн 109,087.0 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч дүгнэлтэд гаргаж зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

3.3. Зөвлөмж

3.3.1. Тайлант онд ажиллагсдад сар бүр үр дүнгийн урамшууллыг 40 хүртэлх хувиар тооцон нийт 601,165.8 мянган төгрөгийн урамшуулал олгосон байхад Баянхонгор Эрчим хүч ЦТХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 05 дугаар тушаалаар 2024 оны жилийн үр дүнгийн урамшуулалд 386,695.6 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.

Энэ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:”, 15.1.3 дахь “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгож зардал нэмэгдүүлдэг байдалд дүн шинжилгээ хийж Төрийн хэмнэлтийн хуулийг мөрдөж ажиллах, цалин урамшуулалтай холбоотой шийдвэрийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу гаргаж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллага нь "Би Эйч Энд Ди"-ийг гэрээ байгуулан халаалт дулааныг авдаг бөгөөд Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 51 дүгээр тогтоолын хавсралтаар "Үйлдвэр, аж ахуй нэгж, байгууллага"-д борлуулах дулааны тарифыг 2,140 төгрөгөөр тогтоосон байхад "Төсөвт байгууллага"-д борлуулах дулааны тариф 2,360 төгрөгөөр тооцож 13,108.9 мянган төгрөгийн халаалтын зардал илүү төлсөн байна.	1	13,108.9	1	13,108.9				
Цахим төлбөрийн баримтын системээс төлбөрийн баримтын жагсаалтыг татан авч мөнгөн гүйлгээний журналтай тулгаж үзэхэд 46,778.4 мянган төгрөгийн худалдан авалтыг И баримт үүсгээгүй байхад гүйлгээ хийсэн байна.	1	46,778.4			1	46,778.4		
Тухай байгууллагын биет бус хөрөнгөд 12 төрлийн 41,707 м2 газар бүртгэлтэй байгаа бөгөөд цахим санд (egazar.gov.mn)-д 29,037 м2, 23 төрлийн газар бүртгэлтэй байгаа бөгөөд 12,670 м2 газар зөрүүтэй байна.	1	0			1	0		
Тайлант онд өөрийн үйлдвэрлэсэн 1,444,107.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлого авсан бөгөөд тус байгууллагын өмч хамгаалах зөвлөл 1,321,875.6 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтад дүгнэлт гаргасан ба зарим ажлуудын гүйцэтгэлийн дүн зөрүүтэй байна.	1	109,086.9			1	109,086.9		
Дүн	4	168,974.2	1	13,108.9	3	155,865.3		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Зөвлөмж		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Тайлант онд сар бүр үр дүнгийн урамшуулалд 5-40 хувь нэмэгдэлд жилд 601,165.8 мянган төгрөгийн урамшуулал олгосон байхад Баянхонгор Эрчим хүч ХХК-ны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 05 дугаар тушаалаар 2024 оны жилийн үр дүнгийн урамшуулалд 386,695.6 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.	1	398,695.6	1	398,695.6		
Дүн	1	398,695.6	1	398,695.6		

-----oOo-----